

САНАМЖ

- Эхийг уншаад, даалгаврыг зааврын дагуу гүйцэтгээрэй.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ үү.
- Өгсөн зайд цэвэр гаргацтай бичээрэй.

Эх.1

Банхар

Шинэхэн яргуйн үнэр хамар цоргисон нарлаг сайхан өдөр, өндөр уулын энгэрт байх тохилог өвөлжөөний өмнөх бууцанд Банхар гэдэг жижигхэн гөлөг зүүрмэглэн хэвтэнэ. Түүний дэргэд магнай дээрээ хоёр хөөрхөн үсэн эвэртэй Сөөсгөр нэрт цэнхэр ишиг, Цагаадай нэрт хундан цагаан хурга хоёр үсрэн наадна.

Цагаадайн эх сүү муутай төллөсөн бөгөөд Сөөсгөрийн ээж голсон тул тэд хургачин хүүгийн гараас угж хөхдөг билээ.

Өглөө эрт хонин сүрэг бэлчихэд бусад хурга ишиг эхийгээ даган бэлчээрт явахад мань хоёр харин угжтай сүүгээ нэхэн Хонгор хүүг дагаж майлан хоцорно. Нэгэн өдөр Сөөсгөр:

- Банхар аа, Банхар аа! Босоорой. Цагаадай шувуу дагаад явчихлаа гэхэд Банхар: - Хэн? Хаана? Яасан гэнэ ээ? Хаашаа явчлав? гээд үсрэн босов.

Цэнхэр ишиг түүний урд орж дагуулан давхисаар өвөлжөөний араар тойрч ирэхэд “Туслаарай, туслаарай” гэж өрөвдөлтэй майлах дуу сонсогдов. Банхар дөрвөн хөлөө сарвайтал давхисаар хүрч очив.

Түүний дуунаар хэрээ шаазгай хоёр хурганы дэргэдээс дуртай дургүй явгалан нисээд холдолгүй эргэж харан суув...

С.Батжаргал (Монголын хүүхдийн богино өгүүллэгийн дээжис. 2017)



1

“Хамар цоргисон” гэсэн үгийг зохиолд хэрэглэсний учрыг зөв тайлбарласан хэсгийг сонгоорой.

- А. Яргуй дөнгөж ургаж байгааг дүрсэлсэн
- Б. Хавар болж нарлаг болсныг дүрсэлсэн
- В. Яргуйн үнэр хурц, тод байгааг дүрсэлсэн
- Г. Өвөлжөөнд яргуй ургасан болохыг дүрсэлсэн

2

“Сөөсгөр: - Банхар аа, Банхар аа! Босоорой” гэж дуудах болсон нь эхлэл хэсгийн ямар үйл явдлаас шалтгаалсан бэ? Сонгоно уу.

- А. Хонин сүрэг бэлчээрт гарахад хурга, ишигнүүд эхийгээ даган явсан.
- Б. Хурга, ишиг хоёр сүүгээ нэхэн Хонгор хүүг даган хоцорсон.
- В. Банхар гэдэг жижигхэн гөлөг зүүрмэглэн хэвтэж байсан.
- Г. Цагаадай, Сөөсгөр хоёр бууцанд үсрэн наадаж байсан.

3

Хүншүүлсэн дүрслэлтэй хэсгийг сонгоорой.

- А. Банхар гэдэг жижигхэн гөлөг зүүрмэглэн хэвтэнэ.
- Б. Цэнхэр ишиг түүний урд орж дагуулан давхисаар...
- В. Банхар дөрвөн хөлөө сарвайтал давхисаар хүрч очив.
- Г. “Туслаарай, туслаарай” гэж өрөвдөлтэй майлах дуу сонсогдов.

4 Хүүхдүүд “Банхар” зохиолыг уншаад “Цагаадайг, цэнхэр ишиг аварсан” гэж бодсон.

Чи үүнтэй санал нийлэх үү? Сонгоорой.

А. тийм

Б. үгүй

- Хариултаа эхээс жишээ татан тайлбарлаарай.

5 Банхар, Цагаадай, Сөөсгөр гуравт дараа нь ямар үйл явдал тохиолдсон байж болох вэ? Төсөөлөн бодоод, 2-3 өгүүлбэрээр бичээрэй.

Эх.2

Банхар

Саргүй шөнө алсын бараа бүү хэл хөл доорх газар ч харагдахгүй нь хэцүү. Гэрэлгүй орчинд дуу чимээ тод сонсогддог ажээ. Үхэр хивэх, адуу шир шир хийж өвс хазлан идэх нь сонсогдоно. Хааяа нэг хоточ банхар бүдүүн дуугаар “Би байгаа шүү!” гэж хотныхоо бүх малд, халдан довтолж болзошгүй чононд, мөн эзэндээ жижүүрийн мэдээ өгөхөөр хөв хөв хийн хуцах нь сонсогдоно. Чухам энэ л хуцалтын чимээг хот айлын хүн, мал бүгд анхааралтай сонсохгүй ч тэдэнд амгалан нойрсох, ая тухтай амарцгаахад нь туйлын нэмэртэй...

Д.Золбаяр (“Банхар” кино туужийн хэсгээс)

6 “Банхар нохой нь мал сүргээ хамгаалдаг” гэсэн санааг аль эхэд илүү тодорхой дүрсэлсэн бэ? Сонгоно уу.

А. Эх.1

Б. Эх.2

- Хариултаа батлах жишээ өгүүлбэрийг эхээс сонгон бичээрэй.

7

“Эзэндээ жижүүрийн мэдээ **өгөхөөр** хөв хөв хуцах нь сонсогдоно” энэ өгүүлбэрт тодруулсан үгэнд тохирох дүрмийг сонгоорой.

- А. Оноосон нэрийн балархай эгшгийг гээхгүй
Б. Үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх ялгах эгшиг гээхгүй
В. Утга ялгах балархай эгшгийг гээхгүй
Г. Зөөлрүүлэх үүргээр орсон балархай эгшиг гээгдэхгүй

8

Баримт, мэдээллийг хэрэглэн **“Усаа хэмнэж, зөв хэрэглэе”** сэдвээр ятгасан утгатай эх зохион бичээрэй. **(Үгийн тоо: 60**

Баримт.1 Нэг хүн өдөрт дунджаар 50-100 литр ус хэрэглэдэг.

Баримт.2 Нэг дэвтэр
үйлдвэрлэхэд 80 - 100 литр ус
зарцуулдаг.

Баримт.3 Ус багасах үед ургамал ургахгүй болж, хөрс хуурайшдаг.

Баримт.4 “Монгол орны 76 хувь нь хуурайшиж байна” гэсэн судалгаа байдаг.